

2014 Í Í Û ÀÆËÛ Í ÒÀÉËÀÍ

Эдийн засаг стратегийн төлөвлөлт, үйлдвэрлэл, дэд бүтэц, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Аймгийн нийгэм, эдийн засгийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг бүх сум, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин биелэлтийг дүгнэж аймгийн Заса, дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэв.

Өнгөрсөн онтой харьцуулахад хөдөө аж ахуйн салбар ихээхэн ололт амжилт гарлаа. Жилийн эцсийн байдлаар Ховд аймагт 7000 гаруй малчин өрхийн 14600 малчид мал аж ахуйн салбарт ажиллаж байна. 2014 онд малын тоо толгойг таван төрөл дээр өсгөж, 2.625.579 толгой мал тоолуулсан нь өмнөх онтой харьцуулахад 17,1 хувь буюу 384,253 толгойгоор өссөн дүнтэй байна. Үүнээс: тэмээ 20629, адуу 96262, үхэр 138155, хонь 995053, ямаа 1375480 тоолууллаа. Малчид 663,3 тн хонины ноос, 41,1 тн тэмээний ноосны урамшууллаас гадна өнгөрсөн жил 100 тэрбум төгрөг, газар тариалан эрхлэгчид 14 тэрбум төгрөгийн орлоготой ажиллав.

Аймгийн хэмжээнд нийт 2554.3 га-д тариалалт хийснээс 798.6 га-д төмс, 1186,0 га-д хүнсний ногоо, 158,5 га-д үр тариа, 411.2 га-д малын тэжээлийн ургамал тариалж, ургац хураалтын явц 100 хувь буюу төмс 8350.2 тн, хүнсний ногоо 14373.4 тн, малын тэжээлийн ургамал 3155 тн, үр тариа 286,7 тн, нийт 26147,1 тн ургац хурааж авлаа

Дэд бүтэц, бүтээн байгуулалтын хувьд аймгийн төвд 42 МВт-ын дулааны шинэ хоёрдугаар станц барьж, 6,2 км хос магистраль шугам, дулаан дамжуулах 8 төв, хоёрдугаар хэлхээний 1 км шугам сүлжээний хамт бүрэн хийж ашиглалтанд оруулан олон жил хүндрэлтэй байсан дулааны асуудлыг бүрэн шийдвэрлэв.

Цахилгааны 2 дугаар дэд станц, 0,6 кВт-ын 15 км шугам, аймгийн төвийн ачаалал ихтэй 6 трансформаторын хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлж шинэчиллээ. Түүнчлэн Ховд хотод 17 км цэвэр усны шугам, 6,7 км бохир усны шугам барьж ашиглалтанд оруулан, цэвэр усны 2 дугаар станц болон төв цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлсэн эдгээр ажлуудын биелэлт 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ингэснээр Баруун бүсийн тулгуур төв - Ховд хот тэлж хөгжих, суурь асуудлаа бүрэн шийдсэнээр 40.000 хүнтэй Ховд хот ирээдүйд 80.000-аас дээш хүн амтай ногоон хот, бүс нутгийн шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал, үйлдвэрлэл, бизнес, санхүү, тээвэр ложистикийн төв болох хэтийн зорилтоо хэрэгжүүлэх таатай боломж бүрдлээ.

2014 онд Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 683 айлын 24 орон сууц, Төрийн орон сууцны корпорацийн санхүүжилтээр 120 айлын 2 орон сууц, нийт 803 айлын орон сууц баригдаж байна. Үүнээс 286 айлын 18026 м² орон сууцыг ашиглалтанд хүлээн авлаа.



Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 69 барилга угсралтын болон их засварын ажил хийж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 25 барилга байгууламж барьж байгаагаас цэцэрлэг 3, сургууль 5, дотуур байр 2, соёл, спортын төв 3, лабораторийн зориулалттай 4, худалдааны 10 төв нийт 47.771 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилга байгууламж шинээр баригдаж, их засварын ажил хийгдэж байна.

2014 онд Ховд аймгийн нутаг дэвсгэрт нийт 300 гаруй км зам ашиглалтанд орлоо. Үүнд: Бага улаан даваа-Тэмээн хүзүү чиглэлийн 110,8 км авто замын ажлын хөдөлгөөнийг нээж, Бага улаан даваа-Манхан чиглэлийн Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй 103.3 км авто замын 85 км замын хучилт хийгээд байна. Манхан чиглэлийн 85.3 км авто замыг улсын комисс хүлээж авлаа.

Аймгийн төвд 10,4 км хатуу хучилттай авто зам барихаас 5 км зам барих хөрөнгийг улсын төсөвт тусгаснаар ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй байна. Түүнчлэн Зэрэг, Манхан, Жаргалан, Буянт, Цэцэг, Алтай, Үенч зэрэг сумын төвүүдэд нийт 20.474 км авто зам болон 9 у/м гүүр барив. “Шинэ сумын төв” төсөлд Зэрэг сум хамрагдаж хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд эрчимтэй өрнөж байна.

Хөшөөтийн уурхайн талаар баримтлах бодлогын баримт бичгийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, гадаадын хөрөнгө оруулалттай Мо-Эн-Ко компанитай гэрээ байгуулсан нь Ховд аймгийн төдийгүй улс орны нийгэм, эдийн засаг, экспорт, улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэлт, хөдөлмөр эрхлэлт зэрэг олон салбарт чухал ач холбогдолтой ажил боллоо.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Буянт суманд цагт 1200 кг төмс боловсруулах үйлдвэрийг барьж туршилтаар төмсний гурил үйлдвэрлэж эхлээд байна. 2013-2014 онд Жаргалант суманд хөөсөнцөрийн 2 үйлдвэр, барилгын ханын дүүргэлтийн хөнгөн блокны 5 үйлдвэр, замаскны 1 үйлдвэр, төмс боловсруулах 2 үйлдвэр зэрэг нийт жижиг, дунд 60 үйлдвэр ашиглалтанд орж үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд Ховд аймгаас оруулах саналыг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн холбогдох яамдад хүргүүлэв.

Суурь судалгаанд үндэслэн, Монгол улсын хөгжлийн баримт бичгүүдтэй уялдуулж “Ховд аймгийн хөгжлийн стратеги 2015-2025 он” баримт бичгийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлууллаа.



Орон нутагт хөрөнгө оруулалтыг татах, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор “Хөрөнгө оруулалтын талаар аймгаас баримтлах бодлого”-ын баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллав.

Баруун бүсийн хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг Ерөнхий сайдын ивээл доор зохион байгуулж 250 гаруй төлөөлөгчид оролцон, 300 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санамж бичигт аймгийн Засаг дарга гарын үсэг зурав.

2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 268.5 тэрбум төгрөгт хүрч, нэг хүнд ногдох ДНБ 3.3 сая төгрөг боллоо.

Аймгийн нийгэм, эдийн засгийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг сум, байгууллагуудаас санал авч боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаар батлууллаа.

Ховд аймагт улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 69 барилга угсралтын болон их засварын ажил хийж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 25 барилга байгууламж барьж байгаагаас цэцэрлэг 3, сургууль 5, дотуур байр 2, соёл, спортын төв 3, лабораторын зориулалтын 4 нийт 47.771 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилга байгууламж шинээр барих, их засварын ажил хийгдэж байна.

Аймгийн төвд 10,4 км хатуу хучилттай авто зам барих ажлын зураг төсвийг хийлгэн улсын экспертизээр баталгаажуулж, уг замаас 5 км замыг барих хөрөнгийг улсын төсөвт тусгаснаар ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй байна.



Хотын доторх автобусны зогсоолыг нэмэгдүүлэх, орон сууцны хорооллын доторх авто зогсоолын зураг төслийг боловсруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, 900 гаруй авто машины ил зогсоол шинээр барьж, 80 айлын орон сууцны дэргэд дээрээ хүүхдийн тоглоомын талбай бүхий 30 машины дулаан зогсоолыг хувийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад хүлээн авлаа.

Сумдыг өндөр хурдны шилэн кабелийг Мөст, Мөнххайрхан, Дуут, Чандмань, Манхан, Эрдэнэбүрэн, Ховд, Буянт, Дөргөн сумдад суурилуулан, сумдыг өндөр хурдны интернэтэд холбох ажлыг бүрэн хийж дуусгахаар Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Монголын цахилгаан холбоо ХХК-ний Ховд дахь салбар компанитай ОНХС-аас 100 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллав.

Манхан, Дөргөн сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө Шинжлэх ухааны академитай хамтран боловсруулж, Зэрэг сум “Шинэ сумын төв” төсөлд хамрагдан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэж, хөрөнгө оруулалтын ажлууд үргэлжлэн хийгдэж байна.



Аймгийн төвийн эрчим хүчний найдвартай хангамжийг бий болгохын тулд шинээр 35/6 кВ–ийн дэд станцыг барьж, Бичигт, Хайрхан багуудын 0,4 кВ–ын шугам сүлжээг засварлаж, үйлдвэрийн бүсэд 200 кВа–ийн трансформатор шинээр суурилуулав.

Агаарын бохирдлыг бууруулах, цэвэр орчныг бүрдүүлэхээр Жаргалант суманд нийт 101 нам даралтын зуух байгаагаас 18 нам даралтын зуухыг зогсоож төвлөрсөн дулааны станцтай, 30 нам даралтын зуухыг цахилгаанд холболоо.

Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг шийдвэрлэхэд аймгийн давсан орлогоос 50 сая төгрөг хуваарилан, эхний ээлжийн 140 хашаанд цахилгаан авах боломж бүрдүүлэн малчны хороололд 1 км 0.4 кВ–ын ЦДАШ барьж 250 кВа–ын чадалтай трансформаторыг ажилд оруулав..



Хотын 2 дугаар дулааны станцыг хэрэглэгч хүртэл 6.2 км хос магистрал шугам, 8 ш дулаан дамжуулах төв, 2 дугаар хэлхээний 1 км шугамын хамт барьж ашиглатад оруулан 118852 мкв талбай бүхий 31 төсөвт байгууллага, 11 аж ахуйн нэгж, 40 нийтийн болон амины орон сууцыг дулаанаар хангаж хэвийн үйл ажиллагаа явуулж байна.



160 айлын орон сууцны дунд байрлах талбайн тохижилтын ажлыг 134.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, 35 машины далд граж, хүүхдийн тоглоомын талбайг “Даш дөл” ХХК өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ.



Явган болон дугуйн замыг 290 гаруй сая төгрөгийн өртөгөөр барьж байгуулан, гудамжны гэрэлтүүлгийг /110.0 сая/ шинэчлэн, орон нутгийн хөгжлийн сангийн 135.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөөрөг /15.0 сая/, Тарвас /50.0 сая/, Монгол гутал /20.0 сая/, Морин хуур /50.0 сая/ гэх мэт үндэсний онцлогийг харуулсан ногоон байгууламж услах савыг байгуулав.

Малчдын залуу халаа бэлтгэх аймгийн дэд хөтөлбөрийг сум, баг, мэргэжлийн байгууллага болон 17 сумын 18-35 насны 220 залуу малчныг оролцуулан санал авч боловсрууллаа. Малчин эмэгтэйчүүд болон манлайлагч малчдын чуулга уулзалтуудыг ажжилттай зохион байгуулж 200 гаруй малчдыг хамрууллаа.

Малчдын нөхөрлөл хоршоо байгуулах санал санаачилгыг дэмжин аймгийн Засаг даргын албан даалгавар гаргаж ажилласнаар 17 суманд 171 хоршоо байгуулагдсаны 82 нь малчдын хоршоо байв.

Урамшуулалд хамруулахаар 3579 өрхийн хонины 663,3 тн, тэмээний 41.1 тн нийт 698.7 тн ноосны материалыг ҮХААЯ-ны Мал хамгаалах санд хүргүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир тушаасан 657 малчин, мал бүхий өрхийн 790 ширхэг бодын шир, 12134 ширхэг богийн арьсанд 48,3 сая төгрөгийн урамшуулал олголоо.


Мал үржил, эмнэлгийн чиглэлээр мал сүргийг вакцинжуулах, халдваргүйжүүлэх, үржлийн цөм сүрэг байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг ажлуудыг зохион байгуулж, мал сүргийг бүртгэлжүүлэх, ээмэгжүүлэх ажилд 437,4 мянган мал хамруулахаас 96,2 мянган үхэр, 203,4 мянган хонь, 137,7 мянган ямаанд ялган тэмдэглэгээ хийж, 118,7 мянган малыг бүртгэлжүүлж, мэдээллийн сан бүрдүүлээ. Чандмань сумын Бумбат хайрханы бүс нутагт үржүүлж буй улаан ямааны удам, бүл тодорхойлох бүртгэх, аж ахуй биологийн ашигтай шинж чанарыг бататгах үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны доктор Д.Алтангэрэлийн удирдлагаар хийж баталгаажуулалт хийв.

Швейцарийн хөгжлийн агентлагийн хөрөнгө оруулалттай ногоон алт төслийн хүрээнд тэмээ, сарлаг маллаж байгаа малчдыг дэмжих, тэмээ, сарлагийн ноос, сүү, махыг боловсруулж зах зээлд нийлүүлэх малчдыг хоршиж ажиллуулах төслийг амжилттай хэрэгжүүлж, амжилт гаргасан малчдыг шалгаруулж шагнах аймгийн болзлыг шинэчлэн боловсруулсан нь залуу малчдын талархалыг хүлээсэн зүйл боллоо.

Ургамал хамгаалал эрдэм шижилгээний хүрээлэнгээс хийсэн тодотгох судалгааг үндэслэн ҮХААЯ-наас ургамал хамгаалах арга хэмжээний зориулалтаар карате (5%) хор 6500 литр ирүүлснийг аймгийн Засаг даргын 2014 оны А/265 дугаар захирамжаар Манхан, Цэцэг, Зэрэг, Мөст, Мөнххайрхан, Дуут, Чандмань

сумдад хуваарилан 32500 га-д бэлчээрийн хортон царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулж 93,2 хувийн үр дүнтэй хийгдсэн байна.

Худаг уст цэг гаргах тендерээр "Алтайн хар сувд" ХХК Булган, Манхан, Мөст, Мөнххайрхан, Цэцэг сумдын нутагт инженерийн хийцтэй 8 ширхэг худаг гаргахаас 7 худаг гаргаж, "Эвлэл" ХК Буянт, Дөргөн, Дуут, Дарви, Зэрэг, Чандмань, Ховд, Эрдэнэбүрэн сумдын нутагт инженерийн хийцтэй 9 ширхэг худаг шинээр гаргахаас 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр худаг гаргах ажлаа Эрдэнэбүрэн сумаас эхэлж байна.



Дарви сумын нутаг дэвсгэрт 105,2 мянган га газрыг баруун бүсийн аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авч, "Баян нуруу" гэж нэрлэн хилийн цэсийг баталсан Засгийн газрын 2014 оны 299 дүгээр тогтоол гарч отрын бүс нутгийн захиргаа байгуулахаар ажиллаж байна. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлттэй уялдуулан бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллаж байна.

Малын өвчинтэй тэмцэх ажлын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, баруун бүс нутгийг шүлхий өвчгүй, эрүүл, вакцин хэрэглэдэггүй бүс статус авах зорилгоор хийгдэж буй шинжилгээнд аймгийн хэмжээгээр 24 багийн 28 өрхийн 1730 толгой малаас авсан 58 дээжид сорилын шинжилгээ хийв. Бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх 4 дэх удаагийн вакцинжуулалтад 840.9 мянган толгой төл малыг хамруулан шаардагдах вакциныг 17 сумын 48 мал эмнэлэг үйлчилгээний нэгжид хүргүүлснээс 835,0 мянган төл мал хамрагдаж 99,3 хувьтай хийгджээ.

Үхрийн сүрьеэ өвчний шинжилгээг төвийн бүсийн Эрдэнэбүрэн, Ховд, Буянт, Жаргалант сумын 180 толгой үхэрт, ям өвчний шинжилгээг 1960 толгой малд хийж, 100 хувь сөрөг урвал өглөө.

Мал эмнэлэг ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээнд улсын хөрөнгө оруулалтаар 10,6 сая төгрөгийн эмийн бодис зарцуулан малын хашаа, зоорь агуулах, худаг уст цэг, тээврийн хэрэгсэл, бэлчээрийн талбай, хүнсний болон мал түүхий эдийн зах, МАА-н түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг ААНБ-ын 395 м² талбайд ариутгал, халдваргүйжүүлэлт хийв.

Байгалийн голомтот болон шинээр дахин сэргэж байгаа малын өвчний тархалт, голомтыг бүртгэн мал амьтны галзуу, боом өвчний гаралт голомтын судалгааг сум багаар сүүлийн 20 жилээр гаргаж өвчний давтамж эрсдэлийг тогтоож, уг өвчинтэй тэмцэх стратеги боловсруулж баталгаажуулан ажиллав.



Буянт голын 2400 га-гийн услалтын системийн 3 дахь ээлжийн 5 км сувгийн 395,6 га талбайн услалтын системийг “Монгол менежмент төв” ХХК аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж услалтын системийг ашиглалтад орууллаа. Швейцарийн хөгжлийн агентлагийн 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1, 3 дугаар гол сувгуудын туслах шуудуу байгуулах ажлыг хийж гүйцэтгэв.

Энэ онд 3435 м² талбай бүхий 34 хүлэмжээс 28,3 тн өргөст хэмх, 40,2 тн улаан лооль, 0,2 тн чинжүү, 3,4 тн тарвас, 1,12 тн сонгино нийт 73,22 тн ургац хураан авч, шинээр 31,8 га талбайд чацаргана тариалснаар аймгийн хэмжээнд нийтдээ 393,9 га талбайд чацаргана тариалж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд гангийн эрчмийг бууруулах, хүлэмжийн хийн шингээх чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор 30 га газарт ойн зурвас байгууллаа.

Аймгийн байгаль хамгаалах нөхөрлөл, иргэд, малчдын бүлгийн “Байгаль хамгаалах нөхөрлөл ба талуудын хамтын ажиллагаа” сэдэвт чуулга уулзалт, үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 17 сумын аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоо, ТББ-ын төлөөлөл 200 гаруй иргэн оролцож, шилдэг нөхөрлөлөөр Мөст сумын “Цагаан тэмээт” нөхөрлөл, шилдэг байгаль хамгаалах төлөвлөлтийг хэрэгжүүлсэн Зэрэг сумын “Эрдэнийн чулуу” нөхөрлөл, шилдэг менежменттэй нөхөрлөлөөр Мөнххайрхан сумын “Цаст ундарга” нөхөрлөл шалгарч тус бүр 300000 төгрөг, шилдгийн шилдэг нөхөрлөлөөр Алтай сумын “Талын бэл” нөхөрлөл шалгарч 1000000 төгрөгөөр шагнагдлаа.

Аймгийн хэмжээнд агаар бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллогод 106 албан байгууллага, аж ахуйн нэгж хамрагдсанаас 18 байгууллага, аж ахуйн нэгж өнгөрсөн онд дулааны нэгдсэн эх үүсвэрт, 22 байгууллага, аж ахуйн нэгжүүд цахилгаан эрчим хүчний халаалтад холбогдлоо.

Аймгийн Засаг даргын захирамжаар “Мянган мандал, түмэн цэцэг” болзолт уралдаан зарлаж, 65 албан байгууллага, аж ахуйн нэгжүүд гаднах талбай болон нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ногоон байгууламжаа сайжруулав.

Ховд Их сургууль дээр БОНХЯ-аас 9 сая төгрөгийн санхүүжилтээр “Экологи”-ийн сургалт сурталчилгаа, мэдээллийн төв байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа нь байнгын, тогтвортой, тасралтгүй, богино хугацаанд бага зардлаар

баруун бүсийн ард иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд ард иргэдийн саналыг сонсон, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хамтран ажиллах боломжийг бүрдүүллээ.

Жаргалант сумын ИТХ-ын тогтоолоор Буянт голын сав дагуу дагаж мөрдөх журам батлан мөрдүүлж, Буянт голын эргийн дагуу 2000 метр урттай усан захын тэмдэгжүүлэлт хийж, 40 ширхэг шон, 4 мэдээллийн самбар байрлуулан, зуслангийн айлуудад нийтийн бие засах газар, хогийн сав байрлуулж, Буянт голын онцгой хамгаалалтын бүсээс 25 иргэний торыг буулгаж 29,8 га газрыг чөлөөллөө.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд эрүүл мэндийн асуудлыг тусгах нь” сэдэвт сургалтад аймгийн БОГ, ЭМГ, МХГ-ын холбогдох мэргэжилтнүүд хамрагдаж 7 удаагийн гаралтаар 25 пуужин харваж хур тунадасны хэмжээг 56,6 хувиар нэмэгдүүлж ажиллалаа.

Ахуйн үйлчилгээний барилгын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох хяналтын байгууллага, гүйцэтгэгчид үүрэг чиглэл өгч ажиллалаа. Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд сумдад ахуйн үйлчилгээ, бизнес инкубатор төв байгуулах зорилтыг тусган хяналт тавьж ажилласнаар Мөст сум “Туяа” нэгдлийн хуучин барилгыг 30,0 сая төгрөгөөр ахуйн үйлчилгээний төв болгон ашиглахаар засварлаж, Буянт суманд 99 м² бүхий 6 өрөөтэй, Эрдэнэбүрэн суманд 108 м² 3 өрөө бүхий ахуйн үйлчилгээ, бизнес инкубатор төвийг ОНХС-гийн хөрөнгөөр барилаа.

Буянт суманд хоногт 1200 кг төмс боловсруулах үйлдвэрийг ОНХС-гийн хөрөнгөөр “Сутайн цамхаг” ХХК барьж тоног төхөөрөмжийг суурилуулан туршилтаар төмсний гурил үйлдвэрлэж байна. Уг үйлдвэр нь пүнтүүз, чипс, төмсний гурил үйлдвэрлэх юм.



Битүү худалдааны төв байгуулах Засгийн газраас зарласан тендэрт “Ус - орчин” ХХК шалгарч Ерөнхий сайдын багцаас 3663.0 сая төгрөг, Ховд аймгийн 400 гаруй бизнес эрхлэгчид 1015.0 сая төгрөг нийт 4678.0 сая төгрөгөөр 96:44 хэмжээтэй, 10 метр өндөр, 8160 метр квадрат талбай бүхий 500 гаруй павильон, лангуутай худалдааны төвийг барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Уг худалдааны төвийн ашиглалтын асуудлыг Төрийн өмчийн хорооноос аймгийн Засаг даргад хариуцуулсан бөгөөд худалдааны төвийн ашиглалт, хамгаалалт хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 132 тоот тогтоолоор “Ховд эе эвийн хүч” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж дүрмийг батлан улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авч үйл ажиллагааг нь эхлүүллээ.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг шинэчлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн 127 дугаар тогтоолоор батлуулж, журмын 4 дүгээр зүйлийн 4.14-д борлуулсан архи, согтууруулах ундааны шил лонхыг буцаан авах тухай заалтыг тусган хэрэгжүүлж байна.

Жаргалант суманд “Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК, “Идэр пума” ХХК-ий хөөсөнцрийн үйлдвэрүүд байгуулагдан үйл ажиллагаа эхэлсэн. Барилгын ханын дүүргэлтийн хөнгөн блокны 5 үйлдвэр байгууллаа.

Аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж, бизнес эрхлэхэд хүндрэлтэй байгаа асуудал, төрийн захиргааны байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаар харилцан зөвлөлдөж, санал солилцлоо. “Элбэг дэлбэг цагаан сар-2014” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 63 аж ахуйн нэгж, хувь хүн, 13 сум 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцон, нийт 120,0 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын 70 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн эзэлж байв. Үүнээс гадна “Баруун бүсийн түншлэл-2014” нэртэйгээр баруун аймгуудыг оролцуулан зохион байгуулж, 103 иргэн аж ахуйн нэгж оролцож 150,0 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн дэлгэгдсэнээс 44,6 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС